



**“УЛААНБААТАР БУК”ХК-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий мэдээлэл

Компанийн нэр	“Улаанбаатар БҮК” ХК
Улсын бүртгэлийн дугаар	9010001027
Регистрийн дугаар	2041219
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Барилгын материал үйлдвэрлэл угсралт
Үүсгэн байгуулагдсан огноо	1996-04-27
Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг хувьцаа	131'547'500 ширхэг
Компанийн дүрэм: ХЭХ шийдвэр огноо, №	2017 он 04 сар 26 өдөр, №2017/06
Утасны дугаар:	976-70001182
Албан ёсны хаяг	Баянгол, 20-р хороо, “УБ БҮК” ХК – байр
Шуудангийн код	18031
Вэб сайт:	http://www.ubbuk.mn
И-мэйл:	info@ubbuk.mn
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр	Grant Thornton Audit LLC 9th fl, Dalai Tower, UNESCO Street 31 Sukhbaatar District Ulaanbaatar 14230, Mongolia

Үйл ажиллагааны өөрчлөлт, шилжилт

2022 оны IV улирлын байдлаар компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй болно.

Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлсэн байдал

Үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, хүчин чадал нэмэгдүүлэх чиглэлээр 4 төрлийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн явц дунджаар 79 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой гэрээ, хэлцэл

2022 оны жилийн эцсийн байдлаар компанийн хөрөнгийн үнийн >10% тэнцэх хөрөнгийн холбоотой аливаа гэрээ, хэлцэл хийгдээгүй.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУДЫН ХЭРЭГЖИЛТ

Компанийн удирдлагын талаарх мэдээлэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

№	Овог	Нэр	Хараат бус байдал	Мэргэжил	Ажлын туршлага	Хувьцааны эзэмшлийн хувь, хэмжээ
1	Даваа	Нямхүү	Ердийн гишүүн	Технолог инженер	-1998-2000 “Монциркон” ХХК, Ерөнхий захирал - 2004-2008 НИТХурал, Төлөөлөгч - 2008-2012 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Дэд сайд - 2012-2014 “УБ БҮК” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн - 2015-2016 Аж үйлдвэрийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга - 2016-2017 “Улаанбаатар менежмент”ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн - 2017-хойш “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн дарга	
2	Дорж	Мөнхөө	Ердийн гишүүн	Физикч	-1988-1989 “Шинжлэх ухааны хүрээлэн”, мэргэжилтэн - 1989-1991 УАЗТЭШ төв, инженер - 1992-2000 “Монциркон” ХХК, захирал - 2001 оноос одоог хүртэл “Улаанбаатар Менежмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал -2010 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	219249 ш/0,0017%/
3	Чапанов	Мухамед Абракович	Ердийн гишүүн	Санхүү менежер	- 2010-2012 онд: “Орион интернейшнл”ХХК-ийн орлогч захирал - 2012-2013 онд: “Улаанбаатар менежмент” ХХК-д санхүүгийн менежер - 2013-одоог хүртэл “Улаанбаатар менежемент”ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн - 2013 оноос одоог хүртэл “Улаанбаатар менежемент”ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал - 2020 оноос “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	113580 ш/0,00086%/
4	Хамхоев	Харон Юсупович	Ердийн гишүүн	Эдийн засагч	- 1990-1992“Лион ЛТД” ХХК, орлогч захирал - 1994-1997“Браз” ХХК-ийн Бээжин дэхь төлөөлөгчийн газар, орлогч захирал - 1992-1994“Браз” ХХК-ийн Казакстан дахь төлөөлөгчийн газар ,орлогч захирал	

					<p>- 1995-2000“Орион Интернейшл” ХХК, ТУЗ-ийн дарга</p> <p>- 2000 оноос одоог хүртэл “Улаанбаатар менежмент”ХХК-ийн ТУЗ-ийн дарга</p> <p>-2010 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн</p>	
5	Хадбаатар	Золжаргал	Ердийн гишүүн	Математикч	<p>Шинжлэх ухаан, техник, дээд боловсролын улсын хороо-Эрдэм шинжилгээний ажилтан</p> <p>“Таван сум”ББХК-Ерөнхий захирал</p> <p>“Шинэст”ХК-дэд захирал</p> <p>Хөдөлмөр нийгмийн хамгаалал улсын хяналтын албанд мэдээлэл гадаад харилцааны хэлтсийн дарга</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</p> <p>2019 -2020 онд: “УЛААНБААТАР МЕНЕЖМЕНТ” ХХК-ийн Судалгаа хөгжлийн асуудал эрхэлсэн захирал</p> <p>2020 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>2020 оноос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн</p>	
6	Отгонсүрэн	Басанхүү	Ердийн гишүүн	Физикч, багш	<p>1989-1991 онд МУИС-д багш,инженер</p> <p>1991-1996 онд “Монгол газар “ХХК-д менежер</p> <p>1998-2003 онд “Монциркон”ХХК-д менежер</p> <p>2004-2009 онд “МЭАТ”ХХК-д Дэд захирал</p> <p>2010 оноос одоог хүртэл “Метаалресурс”ХХК-ийн захирал</p> <p>2020 оноос “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн</p>	

7	Громов	Сергей Борисович	Хараат бус	Инженер	<ul style="list-style-type: none"> - “Trans World” компани – Сангийн хэлтсийн дарга - “Разноимпорт” компани – Менежер - “АПУ”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн - “Монгол даатгал”ХХК-ийн ТУЗ-ийн дарга - “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн 	
8	Галнэмэх	Цогнэмэх	Хараат бус	Бизнес удирдлага	<ul style="list-style-type: none"> - 1998-2001 онд: “Проктер энд Кембл”-Төв Ази, Кавказийн худалдааны сүлжээ хариуцсан менежер - 2001-2004 онд:”М-Си-Эс Кока-Кола “ХХК- борлуулалт хариуцсан захирал - 2004-2006 онд: “Проктер энд Кембл”-Төв Ази, Кавказ улс хариуцсан менежер - 2004-2006 онд: “Анунгоо”ХХК, “Проктер энд Кембл” дистрибьюторын Гүйцэтгэх захирал - 2006-2007 онд:”Анун”ХХК-ийн Гүйцэтгэх захирал - 2007-2010 онд: “М-Си-Эс Дистрибьюшин”ХХК-ийн Гүйцэтгэх захирал - 2010-2011 онд: “Тэнгэр групп” Бизнес хөгжил хариуцсан дэд Ерөнхийлөгч - 2011-2012 онд: “Бишрэлт Холдинг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал - 2013-2015 онд: “Ремикон”ХК-ийн Гүйцэтгэх Захирал - 2015-2016 онд: “Грийн сити” ХХК-ийн борлуулалт хариуцсан захирал - 2017 –оос одоог хүртэл “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн 	
9	Чулуундорж	Энхбат	Хараат бус	Инженер	<p>2004-2008 онд:Тээвэр үйлчилгээний дарга</p> <p>2008-2012 онд: “Сан транс” ХХК-д Гүйцэтгэх захирал</p> <p>2012-2016 онд:Нийслэлийн Тээврийн газрын дарга</p> <p>2017 оноос одоог хүртэл “АХОИ” ХХК-д Ерөнхий захирал</p> <p>2021 оноос “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн</p>	

ТУЗ-ийн гишүүдийн хуралд оролцсон оролцоо:

№	Гишүүний нэр	15-Feb	11-Mar	18-Apr	21-Apr	19-May	1-Jul	25-Jul	1-Aug	23-Nov	ирц %
1	Д.Нямхүү	1	1	1	1	1	1	1	1	1	100%
2	Д.Мөнхөө	1	1	1	1	ч	1	1	1	1	88.8%
3	С.Б.Громов	1	1	1	1	1	1	1	1	1	100%
4	Хамхоев.Х.Ю	1	1	1	1	ч	1	1	1	ч	77.7%
5	М.А.Чаланов	ч	1	1	1	1	ч	ч	1	ч	44.4%
6	Х.Золжаргал	1	1	1	1	1	1	1	1	1	100%
7	Г.Цогнэмэх	1	1	1	1	1	1	1	1	1	100%
8	О.Басанхүү	1	1	1	1	1	1	1	1	1	100%
9	Ч.Энхбат	1	1	1	1	1	1	1	1	1	100%

Гүйцэтгэх удирдлагын баг

№	Овог нэр	Албан тушаал	Хүйс	Томилогдсон огноо	Мэргэжил
1	Х.Золжаргал	Гүйцэтгэх захирал	эр	21/05/2020	Математикч
2	Р.Г.Мирзоев	Үйлдвэрлэл эрхэлсэн захирал	эр	11/04/2020	Уулын инженер
3	Д.Сувд	Санхүү эрхэлсэн захирал	эм	03/15/2012	Хэрэглээний
4	Н.Хунцэнгэл	Үйл ажиллагаа эрхэлсэн	эм	20/10/2020	Бизнесийн удирдлага
5	Б.Нармандах	Ерөнхий инженер	эр	03/25/2013	Металургийн инженер
6	Б.Сапербек	Үйлдвэр техник технол дарга	эр	05/08/2020	Барилгын инженер
7	Б.Байнахүү	Ерөнхий нягтлан бодогч	эр	25/05/2020	Нягтлан бодогч

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсаны дагуу “Улаанбаатар БҮК ХК-ийн ТУЗ-ийн 2022-5-19 -ний өдрийн №2022/13 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан.

Тус хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодексст нийцүүлэх ажлыг хийхээр дараах байдлаар төлөвлөж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

№	Хийх ажлууд	Хариуцах эрх бүхий албан тушаалтан, хороо	Гүйцэтгэх албан тушаалтан	хугацаа
1	"Компанийн засаглал"-ын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулж батлах	ТУЗ-ийн дарга Д.Нямхүү	ТУЗ-ийн дарга нарийн бичгийн дарга Д.Байгальмаа	2-р улиралд
2	ТУЗ-өөс 2013-2018 онуудад баталж хэрэгжүүлж буй одоогийн журмуудад нэмэлт өөрчлөлт оруулан батлуулах	ТУЗ-ийн дарга нарийн бичгийн дарга Д.Байгальмаа	Хуульч Д.Пүрэвцэрэн	2-р улиралд

3	Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж батлах	Нэр дэвшүүлэх хороо	Хуульч Д.Пүрэвцэрэн	3-р улиралд
4	Цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичиг боловсруулах, батлах	Цалин урамшууллын хороо	Санхүү эрхэлсэн захирал Д.Сувд	4-р сард
5	Дотоод аудитын журам, бүтцийг батлах	ТУЗ-ийн дарга Д.Нямхүү	Аудитын хороо	5 сард
6	Эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавих /Эрсдлийн хорооны чиг үүргийг Аудитын хороонд хариуцуулж болно. 5.2/	ТУЗ-ийн дарга Д.Нямхүү	Дотоод аудитын нэгж	2-р улиралд
7	Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа талаарх тайлан мэдээлэл бэлтгэх	Гүйцэтгэх захирал Х.Золжаргал	ХАБЭАБО-ы албаны дарга Л.Эрдэнэцэцэг	улирал бүр
8	Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг батлах	Гүйцэтгэх захирал Х.Золжаргал	Үйл ажиллагаа хариуцсан захирал Н.Хунцэнгэл	3-р улиралд
9	Компанийн дотоод журамд ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх асуудлуудыг тусгах.	Гүйцэтгэх захирал Х.Золжаргал	Үйл ажиллагаа хариуцсан захирал Н.Хунцэнгэл	3-р улиралд
10	Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавих	Гүйцэтгэх захирал Х.Золжаргал	Үйл ажиллагаа хариуцсан захирал Н.Хунцэнгэл	3-р улиралд
11	Компанийн эрх бүхий албан тушаалтан, холбогдох мэргэжилтэн, ажилтнуудад "Компанийн засаглалын кодекс"-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээлэл өгөх, мөн түүнчлэн тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтод зохих нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах ажил зохион байгуулах	ТУЗ-ийн дарга Д.Нямхүү	ТУЗ-ийн дарга нарийн бичгийн дарга Д.Байгальмаа	2-р улиралд
12	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тайлагнах	ТУЗ-ийн дарга Д.Нямхүү	ТУЗ-ийн дарга нарийн бичгийн дарга Д.Байгальмаа	хагас, бүтэн жилээр

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	6	50%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	5	50%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	4	66%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%
5	Эрсдэлийн удирдлага	8	5	62%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	5	62%
8	Компанийн соёл	6	3	50%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	7	70%
	Нэгдсэн дүн	72	44	61,1%

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улаанбаатар БҮК ХК- нь үндсэн гурван нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

- Төмөр бетон хийц эдлэл /ТБХЭ/: стандарт бүтээгдэхүүнээс гадна стандарт бус төмөр бетон хийц эдлэлийг өгөгдсөн хийц загвар, хэмжээс бүхий зураг төслийн дагуу үйлдвэрлэх хүчин чадал жилд 30000 м3
 - Волтамикс (Хоолой/Цагираг)
 - Тенсиланд (Хучилтын нүхт хавтан):
 - Бусад ТБХЭ: 14736 м3
 - Авто замын хашлага
 - Лотки
 - Бусад
- Төмөр замын төмөр бетон дэр
- Метал хийц

Тайлант хугацаанд хүрсэн гол үр дүн

Стратегийн зорилго	Гол үр дүн, оны эхнээс өссөн дүнгээр
Том бүтээн байгуулалтад оролцоогоо нэмэгдүүлж бизнесийн өсөлт, ашигт ажиллагааг сайжруулна	<p><u>Үйлдвэрлэл:</u></p> <ul style="list-style-type: none"> ТБХЭ: нийт 37807м3 үйлдвэрлэсэн. Метал хийц: 283 тонн Бутлуур: Төлөвлөгөө 116% биелэсэн: <ul style="list-style-type: none"> Нийт 69684м3 хайрга дайрга угааж, буталж ангилсан <p><u>Борлуулалт:</u></p> <ul style="list-style-type: none"> Тайлант хугацаанд 94 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулалтын гэрээ хийсэн ба төлөвлөгөөний биелэлт 155% байна. Борлуулалт 72.085 тэрбум төг-тэй тэнцэж, төлөвлөгөө 114% биелэв.
Хэрэглэгчид хүргэх үнэ цэнийн сайжруулалтад төвлөрч зах зээлийн нэр хүнд, тэргүүлэгч	<p><u>Шинэ бүтээгдэхүүн:</u></p> <ul style="list-style-type: none"> <u>35-110кВт-ын СК шон</u> <u>0.4-15кВт ЦДАШ шон</u> <u>60х60 80х80мм шон</u> <u>ТЗ-ын суман шилжүүлэгийн бетон дэрний шугам</u>

байр сууриа бэхжүүлнэ	
Үйл ажиллагааг стандартад нийцүүлж бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, үр ашиг, бүтээмжийг сайжруулна, аюулгүй ажиллагааг хэвшүүлнэ	<p><u>Лаборатор:</u></p> <ul style="list-style-type: none"> • MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагын дагуу №“TL 178” итгэмжлэгдсэн лабораторийн гэрчилгээ авсан. <p><u>Чанар хяналт:</u> Арматурчлал, хэв үйлдвэрлэл, ТБХЭ цутгалтын өмнө ба дараа, болон бэлэн бүтээгдэхүүний чанарын хяналт шалгалтыг батлагдсан зураг болон стандартын шаардлагын хүрээнд хийж гүйцэтгэв</p> <p><u>ISO стандарт:</u></p> <ul style="list-style-type: none"> • Ажлын хэсэг төслийг төлөвлөж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн • ISO стандартын сургалтыг тогтмол 7 хоног тутамд 3-4 цагаар хийв • Компанийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж зөвлөх үйлчилгээний үнэлгээний эхний тайланг хүлээж авсан • Үнэлгээний дагуу стандартын шаардлагын хэрэгжилт явагдаж байна <p><u>Эрчим хүчний хэмнэлт:</u> Цахилгаан эрчим хүчний хэрэглээ 0.5%-р буурсан</p>
Үйлдвэрлэлийн хүчин чадал, техник технологи, менежментийн тогтолцоо, хүний нөөцийг хөгжүүлэх замаар байгууллагын чадавхийг бэхжүүлнэ	<p><u>Үйлдвэрлэлийн хүчин чадал/Технологи сайжруулалт:</u></p> <ul style="list-style-type: none"> • M1100-M1300 маркийн бетон зуурмагийн тохирлын гэрчилгээ авсан. • <u>Дүүргэгч материал:</u> Фракцыг 0÷5/5÷10/10÷20 хэмжээст байсныг 0÷3/3÷8/8÷13/13÷20 болгон өөрчилж шинэчлэн, орц нормын туршилт хийж үйлдвэрт нэвтрүүлэв • <u>ТЗТБДэр:</u> Уурын боловсруулалтын цагийг багасгах туршилт хийх замаар гарцыг хоногт 2000ш болгон нэмэгдүүлэв. • <u>Хүчитгэлийн рам:</u> 18.7м, 25.3м дам нуруу, суман шилжүүлэг зэрэг урьдчилсан хүчитгэлтэй эдлэлд зориулан хүчитгэлийн рамны 2 суурь цутгагдсан, төхөөрөмж суурилуулахад бэлэн болсон • <u>Лазер зүсэгч:</u> Машины паспорт боловсруулж ажилд оруулсан • <u>Бутлуур:</u> <ul style="list-style-type: none"> ○ Чулуу бутлах, бохир хайрга угаах үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор лаг шаврын нуурны шороон даланг 370 метр төмөр бетон хашаагаар сольж, 2 тасалгаа гарган, бетон шалтай болгож сайжруулсан. ○ 4YZS, 2YZS том, жижиг шигшүүрийн элэгдэж муудсан усны труба болон үйлдвэрийн элс угаагч төхөөрөмжийг бүтэн шинэчилсэн <p><u>Инженерийн шугамууд, үйлдвэрийн ТТ-ийн засвар үйлчилгээ:</u></p> <ul style="list-style-type: none"> • Тенсиланд, Вольтамикс шугам, Цементийн силос засвар бүрэн хийгдсэн • <u>Цахилгаан:</u> <ul style="list-style-type: none"> ○ БА3-3 ын автоматик программ хангамж болон 565м кабелийг бүрэн шинэчилж, удирдлагын самбар угсрав ○ 1-6 пролётын ерөнхий тэжээлийн кабелийн шинэчлэл: ашиглалтын хугацаа дууссан кабель шугамыг солив ○ Гадна ачилтын талбайн крануудын ашиглалтын хугацаа дууссан кабель, шитийг шинэчилж шөнийн цагт бүх краны хүчдэлийг автоматаар салгадаг болов ○ Бутлуурын 2 км кабелийг бүрэн шинэчлэн удирдлагын шит угсрав • <u>Гүүрэн кран:</u> <ul style="list-style-type: none"> ○ БА3-3-ын хуурай нэмэлт өргөх цахилгаан тайлыг шинэчилсэн ○ Пролет-6 дахь гүүрэн краны цахилгаан удирдлагын самбарын шинэчлэлт, механик тоноглолын засвар дууссан ○ Цахилгаан монтажийн шинэчилэлт: Үйлдвэрийн 3 кранд хийсэн, гадна талбайд 1 гүүрэн краныг монтажласан

	<p>○ Баз-4 дээр 2тн цахилгаан тайл хийгдсэн</p> <p><u>Компанийн гадна тохижилт:</u></p> <ul style="list-style-type: none"> • Компанийн ногоон байгууламжийг шинэчилж зүлэгжүүлсэн. • Гадна талбайд шинээр сүүдрэвч, түшлэгтэй сандал, хогийн бункер, эко бялдаржуулах төхөөрөмжүүд үйлдвэрлүүлэн суурилуулсан. <p><u>Архив, бичиг баримт хөтлөлт:</u></p> <ul style="list-style-type: none"> • 1999-2013 оны 33 боть (4252х) баримт скайнардан цахим архив үүсгэсэн <p><u>Хүний нөөц, дотоод хяналт:</u></p> <ul style="list-style-type: none"> • Жилийн эцсийн байдлаар нийт 287 ажлын байранд шинээр ажилтан шалгаруулж авсан ба 43 ажилтныг албан тушаал дэвшүүлсэн. • Цалин хөлсний бодлого, журам, гүйцэтгэлийн удирдлагын журам боловсруулан хэрэгжүүлэв • ХНХЯ-наас мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ авсан. Ингэснээр оосорлогч дохиочин, бетон арматурчин, гагнуурчин, кран оператор, гүүрэн краны оператор зэрэг мэргэжлийн сургалт явуулахад бэлэн болсон. • Нийт 13 чиглэлээр сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 60-70 хүн хамруулав • Нийт 16 гомдол хүлээн авч хянасан, 12 удаагийн зөрчлийн шинжтэй үйл ажиллагааг илрүүлж зохих арга хэмжээг авхуулж дүнг танилцуулсан • Хяналтын камер ашиглалтын журам боловсруулж мөрдүүлсэн
--	--

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛ, КОМПАНИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр эвдэрсэн хөрснөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор шороон талбай болон ачилтын хэсгийн нийт 1152 м² талбайг мөн шинээр тавьсан тээврийн хэрэгсэл зорчих авто замын 24м² талбайг цементэлэн хатуу хучилттай болгов.

- Компанийн ажлын байруудад угаарын хийн болон цулцанд нэвтэрдэг тоосны хэмжилтийг хийж зохих арга хэмжээг авав.

- Үйлдвэрийн гадна хэсгийн олон замын хөдөлгөөнийг багасган нэг замтай болгосон ба машины зогсоол, тэмдэглэгээний зохион байгуулалтыг сайжруулав.
- Хогийн цэгээс үүдэлтэй их хэмжээний тоосжилтыг бууруулах зорилгоор зохион байгуулалтын арга хэмжээ авч тогтмол гэрээт байгууллагад нийлүүлэх ажлыг хэвшүүлэв.

Усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаа, Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран ажиллаж, холбогдох зөвшөөрлийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллаж байна. Ингэснээр саарал усны алдагдлыг багасгах зорилгоор 6м-ийн урттай 55 ш бетон хашаа ашиглан лагны шороон даланд бетонон хана босгож 2532 м² талбайг бетонон шалтай болгож шинэчлэл хийснээр 2021 онд 1м³ материал үйлдвэрлэхэд 1.04 м³ ус зарцуулсан бол 2022 онд 1м³ материал үйлдвэрлэхэд 0.46 м³ ус зарцуулж 1м² материал үйлдвэрлэхэд зарцуулах усны хэмжээг 52%-иар бууруулсан болно.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд

Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.2-т заасны дагуу Газрын төлөв байдал, чанарын захилгат хянан баталгааны ажлыг “Богдын өндөр сүрвэй” ХХК-аар хийлгүүлэн зөвлөмжийн дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Компанийн ойр орчмын халзарсан газрыг хөрсөөр өнгөлөн тэгшилж 746м² талбайг зүлэгжүүлэх арга хэмжээ авсан ба мөн Ухсан нүх, суваг, халцарсан газрыг үржил шимт хөрсөөр өнгөлөн тэгшлэж, өвс ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг тухай бүр хийж ажиллаж байна.

Ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд

Компанийн ойр орчмын ногоон байгууламжид нийтдээ голт бор-20ш, буйлс-20ш, шар хуайс-420ш, хайлаас-80ш, монос-40ш, нарс-9ш суулган нөхөн сэргээлт хийж цэцэрлэгжүүлсэн.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Үйлдвэрийн орчинд бүх төрлийн хатуу, шингэн хаягдлын жил тутам үүсэх, боловсруулах, цэвэрлэх тоо хэмжээ, нэр төрөл, шинж чанарын шинжилгээ дүгнэлт хийж хог хаягдлын тухай хуулийн 10.2.1, 10.2.2-т заасны дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг 3 өнгийн хогийн саванд ангилан үйлдвэрт 8 газар, нийт хогийн цэгийг аюулгүй бүсэд байршуулав.

Химийн бодисын байгаль орчны нөлөөлөлийг бууруулах хүрээнд

Тус компанид ашиглаж буй химийн бодисд судалгаа хийн хор аюулын мэдээлэх хуудсаар мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Үүнд:


Химийн агуулахыг сайжруулах ажлын төлөвлөгөөний дагуу Химийн агуулах №1-ийн засварын ажлыг гүйцэтгэсэн ба, “Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүн агуулахын барилгад тавих ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандартын шаардлагын хэмжээнд хүргэх зорилгоор Химийн агуулахын зөвшөөрөл авч Химийн

агуулахуудын галын дүгнэлт, Химийн агуулахуудын цахилгааны газардуулгын эсэргүүцэл хэмжсэн протоколыг холбогдох хууль тогтоомжийн гаргуулж, Галын самбар-1ш, 35 кг -ын хор 1 ширхэг, 4 кг-ын хор 4 ширхэг байрлуулж, химийн бодисуудыг хаягжуулав.

Мөн түүнчлэн химийн агуулахад химийн бодистой харьцахад хэрэглэх ажлын хувцас, нэг бүрийн хамгааалах хэрэгслийг байршуулж аюулын душыг хийлгэв.

Хими–Физикийн лабораторийн стандартын шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор Лабораторийн дээжийн өрөөг химийн агуулахад байршуулж, тоног төхөөрөмжүүдийг стандартын дагуу байрлуулав.

2022 оны жилийн зорилтын биелэлт: жилийн эцсийн байдлаар Компани нь 2022 оны бизнес төлөвлөгөөгөөр нийт 20 үзүүлэлт (тоо хэмжээ, чанар, хугацаа болон өртөг) –ээр “Хүрэх түвшин”-г төлөвлөсөн ба биелэлт 98%-тай байна.



Эдийн засгийн статистик мэдээ

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Эргэлтийн харьцаа: ЭХ/БХӨТ	0.36	1.11	1.77	1.19	1.19	1.43	2.13	2.1	1.48
Төлбөр ТГ чадвар (ЭХ-БМ)/БХӨТ	0.13	0.46	0.76	0.39	0.71	0.66	0.56	0.5	0.25
Өрийн түвшин: ӨТ/ЭӨ	38%	12%	15%	20%	33%	25%	26%	35%	62.2%
Эздийн өмчийн өгөөж (ЦА/ЭӨ), %	2%	-4%	-6%	-6%	2%	7%	23%	24%	4.2%

Өмнөх онтой харьцуулсан санхүүгийн харьцаанууд

Санхүүгийн харьцааны үзүүлэлт	Тооцсон үзүүлэлт	2020 он	2021 он	2022 оны гүйц
Төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдалд хийсэн шинжилгээний үр дүн				
Өөрийн Капиталын оролцоо %	ӨК/НХ	80.27%	74%	61.6%
Эргэлтийн Харьцаа	ЭХ/БХӨ	2.13	1.8	1.48
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	(ЭХ-БМ)/БХӨ	0.6	0.3	0.25
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн харьцаа	НӨ/ЭӨ	0.25	0.351	0.62
Өрийн харьцаа	НӨ/НХ	0.20	0.26	0.38
Өр төлбөр ба авлагын харьцаа	БХӨ/Авлага	4.59	5.92	6.64
Хөрөнгийн ашиглалт болон компанийн ашигт ажиллагааны байдалд хийсэн шинжилгээний үр дүн				

Нийт хөрөнгийн эргэц	НО/НХ	0.98	0.56	0.84
Өөрийн хөрөнгийн ачаалал	БО/ӨК	1.22	0.75	1.36
Үндсэн хөрөнгийн эргэц	БО/ЭБХ	1.69	1.03	1.92
Авлага цуглуулах дундаж хугацаа	Ав/БО*360	15.64	30.38	25.13
Бараа материалын эргэц /удаа/	ББӨ/БМ	1.92	0.90	1.30
Ашгийн норм /нийт ашгаар тооцсон/	НА/БО	0.40	0.40	0.27
Ашгийн норм /Ү.А-ны ашгаар /	ҮАА/БО	0.15	0.32	0.22
Ашгийн норм /цэвэр ашгаар /	ЦА/БО	0.19	0.08	0.03
Ашигт ажиллагаа	ЦА/ЭӨ	23%	6%	4.2%
Нийт хөрөнгийн өгөөж	ТӨЦА/НХ	0.23	0.05	0.03
Өөрийн хөрөнгийн өгөөж	ТӨЦА/ӨК	0.29	0.064	0.05

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Хувьцааны мэдээлэл

Өмнөх өдрийн хаалт	400
Нээлтийн ханш:	0
Хаалтын ханш:	N/A
Тухайн өдрийн VWAP	0
Авах дээд үнэ:	380.00x305
Зарах доод үнэ:	400.00x5,000
Нийт хувьцааны тоо ширхэг:	131,547,500
Гаргасан хувьцааны тоо ширхэг:	131,547,500
Арилжигдсан ширхэг:	0
Арилжааны үнийн дүн:	46471786.2
Хэлцлийн тоо:	0
52 долоо хоног:	380.10-755.00
Зах зээлийн үнэлгээ:	52,619,000,000.00
ISIN:	MN00BVK01956

Хувьцаа эзэмшигч ба ногдол ашиг хуваарилалтын мэдээ

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч	Тус компанийн хувьцааг эзэмшиж буй байдал		Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал		
	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь	Компанийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
“Улаанбаатар менежмент”ХХК	128,315,700ш	97.5%	Бусад	3,231,800 ш	2.5%

	Хувьцааны тоо	Нэгж хувьцаанд зарласан НА /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	ТУЗ-ийн шийдвэр
2019	131,547,500	4	526.2	2020 оны 2-р сарын 17-ны өдрийн № 2020/01
2021	131,547,500	30	3,946,425,000	2021 оны 2-р сарын 09-ний өдрийн №2021/02
2022	131,547,500	10	1,315,475,000	2022 оны 2-р сарын 15-ний өдрийн №2022/03